



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2025/174/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дорноговь аймаг

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер:

У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

“БАБИ ТАМИ АУДИТ” ХХК-ЫН

Захирал:

З.Ундармаа

Ахлах аудитор:

Т.Золбоо

Аудитор:

Б.Батчимэг

Агуулга

1. Хараат бус аудиторын дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
5.Аудитын илрүүлэлт.....	9
5.1 Залруулсан алдаа.....	9
5.2 Албан шаардлага	9
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	9

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1. Хараат бус аудиторын дүгнэлт



Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: domogovi@audit.gov.mn

᠔᠐᠒5.᠐᠒.᠒5 № 1/8-1᠖᠐

танай _____-ны № _____-т

ДЭЛГЭРЭХ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Э.ЧАНЦАЛДУЛАМ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлыг онцолсон хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант хугацаанд 3,871,210 төгрөгийн цэвэрлэгээний материал болон хогийн уут, 38,500 төгрөгийн галын хорны суурь зэргийг хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардлаас, 9,900 төгрөгийн интернетийн зардлыг эмийн зардлаас, Нэгдсэн эмнэлгийн үзлэгийн төлбөр 319,900 төгрөгийг хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардлаас, аудитын төлбөр 864,000 төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас, даатгалын төлбөр 79,500 төгрөгийг тээврийн хэрэгслийн татварын зардлаас, программын төлбөр 450,000 төгрөгийг эмийн зардлаас тус тус зарцуулж батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж,

442502003

аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/Төгрөгөөр/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	188,280,516.77	332,943,941.94
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	45,654,147.27	4,948,599.48
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	45,654,147.27	4,948,599.48
3121	Төгрөг	45,654,147.27	4,948,599.48
31211	Төрийн сангийн харилцах	45,654,147.27	4,948,599.48
33	АВЛАГА	16,104,949.82	184,289,225.36
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,550,487.82	4,081,620.14
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	180,187,605.22
335	Бусад авлага	11,554,462.00	20,000.00
3351	Байгууллагаас авах авлага	11,534,462.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	20,000.00	20,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	126,521,419.68	143,706,117.10
351	Түүхий эд материал	59,202,397.11	64,102,738.54
35110	Тусгай зориулалттай материал	12,829,261.05	26,331,817.96
35130	Эм боох материал	46,373,136.06	37,770,920.58
354	Хангамжийн материал	67,319,022.57	79,603,378.56
35410	Бичиг хэргийн материал	7,468,640.00	7,150,200.00
35420	Аж ахуйн материал	38,685,998.25	43,784,240.25
35430	Сэлбэг хэрэгсэл	2,015,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	2,423,750.00	2,801,550.00
35450	Барилгын засварын материал	3,000,000.00	6,070,500.00
35460	Хүнсний материал	8,936,326.76	8,363,611.55
35470	Бусад хангамжийн материал	4,789,307.56	11,433,276.76
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	287,502,801.21	997,874,560.33
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	287,502,801.21	997,874,560.33
392	Биет хөрөнгө	279,003,905.13	989,571,831.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	189,397,644.00	815,792,184.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(13,940,495.72)	(31,634,716.73)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	45,050,000.00	137,272,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(20,435,541.75)	(16,491,650.02)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	162,748,001.08	168,157,601.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	(95,838,773.10)	(125,377,732.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,481,089.00	43,580,989.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,409,185.06)	(17,160,875.85)
39214	Бусад үндсэн хөрөнгө	93,701,819.00	110,992,444.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(92,750,652.32)	(95,558,412.81)
393	Биет бус хөрөнгө	8,498,896.08	8,302,729.32
39301	Программ хангамж	2,112,000.00	2,112,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,613,103.92)	(1,809,270.68)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,000,000.00	8,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	475,783,317.98	1,330,818,502.27
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,873,491.80	44,335,412.89
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,873,491.80	44,335,412.89
413	Өглөг	2,873,491.80	44,335,412.89
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,873,491.80	40,865,812.99
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	3,469,599.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	472,909,826.18	1,286,483,089.38
51	Засгийн газрын хувь оролцоо	472,909,826.18	1,286,483,089.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	236,581,519.55	236,581,519.55
51101	Өмч: - төрийн	236,581,519.55	236,581,519.55
512	Хуримтлагдсан үр дүн	157,963,453.89	967,637,875.09
51210	Өмнөх үеийн үр дүн	157,963,453.89	157,963,453.89
51220	Тайлант үеийн үр дүн	-	813,573,263.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	78,364,852.74	78,364,852.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	475,783,317.98	1,330,818,502.27

Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
		/Төгрөгөөр/	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	665,266,155.19	1,748,833,675.70

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,863,284.92	824,527,753.22
120	Нийтлэг татварын бус орлого	35,802,789.61	824,527,753.22
120009	Бусад орлого	60,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	15,510,279.00	792,370,265.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	20,232,510.61	32,157,487.82
122	Тусламжийн орлого	60,495.31	-
122001	Хандив тусламж /дотоод/	60,495.31	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	629,402,870.27	924,305,922.48
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,041,314.15	41,208,737.83
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,041,314.15	41,208,737.83
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	602,361,556.12	883,097,184.65
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	602,361,556.12	883,097,184.65
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	682,843,328.53	914,945,954.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	682,843,328.53	914,945,954.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	682,843,328.53	914,945,954.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	395,519,457.01	549,971,325.22
210101	Үндсэн цалин	228,863,291.38	320,518,089.17
210102	Нэмэгдэл	119,844,659.20	190,764,157.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,409,000.00	13,227,219.00
210104	Урамшуулал	35,402,506.43	25,461,860.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,997,178.83	67,380,492.15
210201	Тэтгэврийн даатгал	35,677,694.76	46,628,973.47
210202	Тэтгэмжийн даатгал	4,213,618.10	5,485,761.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,125,349.31	3,211,577.99
210204	Ажилгүйдлийн даатгал	760,099.38	2,410,835.82
210205	Эрүүл мэндийн даатгал	6,220,417.28	9,643,343.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,175,964.15	34,842,287.83
210301	Гэрэл, цахилгаан	3,222,496.00	3,997,044.83
210302	Түлш, халаалт	11,783,044.00	27,807,091.00
210303	Цэвэр, бохир ус	7,170,424.15	3,038,152.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,192,791.00	52,780,129.00
210401	Бичиг хэрэг	3,565,740.00	6,403,140.00
210402	Тээвэр, шатахуун	21,721,770.00	29,525,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,640,858.00	2,630,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	941,500.00	870,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,254,697.00	13,350,739.00
210408	Бараа материал акталсны зардал	2,068,226.00	-
2105	Нормативт зардал	85,534,597.95	93,909,377.02
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	77,902,389.81	84,340,164.81
210502	Хоол, хүнс	7,632,208.14	9,569,212.21
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,566,650.00	13,117,010.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,012,000.00	1,586,900.00
210604	Урсгал засвар	3,554,650.00	11,530,110.00
2107	Томилолт, зочны зардал	3,192,000.00	8,346,600.00
210702	Дотоод албан томилолт	3,192,000.00	8,346,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,267,021.00	15,009,620.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,169,571.00	11,471,280.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	299,250.00	2,865,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	181,200.00	185,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	29,040.00
210807	Газрын төлбөр	8,000.00	8,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,397,668.59	79,589,113.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,284,375.00	4,858,665.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,113,293.59	74,730,448.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(17,577,173.34)	833,887,721.43
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	100,375.16	20,314,458.23
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	100,375.16	20,314,458.23
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(100,375.16)	(20,314,458.23)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(17,677,548.50)	813,573,263.20

Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	617,988,903.58	755,652,779.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	120,495.31	-
120	Нийтлэг татварын бус орлого	60,000.00	-
120009	Бусад орлого	60,000.00	-
122	Тусламжийн орлого	60,495.31	-
122001	Хандив тусламж /дотоод/	60,495.31	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	617,868,408.27	755,652,779.26
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,041,314.15	41,208,737.83
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,041,314.15	41,208,737.83
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	590,827,094.12	714,444,041.43
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	590,827,094.12	714,444,041.43
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	624,633,437.15	783,311,927.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	624,633,437.15	783,311,927.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	624,633,437.15	783,311,927.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	394,506,071.57	516,213,530.50
210101	Үндсэн цалин	229,432,993.69	260,496,474.46
210102	Нэмэгдэл	119,209,122.45	194,135,625.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,409,000.00	31,384,177.84
210104	Урамшуулал	34,454,955.43	30,197,253.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,344,459.23	62,677,098.00
210201	Тэтгэврийн даатгал	32,090,995.94	41,521,831.29
210202	Тэтгэмжийн даатгал	4,147,597.32	4,828,699.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,125,349.31	2,414,699.42
210204	Ажилгүйдлийн даатгал	760,099.38	4,252,868.58
210205	Эрүүл мэндийн даатгал	6,220,417.28	9,658,999.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,175,964.15	34,842,287.83
210301	Гэрэл, цахилгаан	4,040,159.00	4,930,659.83
210302	Түлш, халаалт	12,174,779.74	25,711,628.00
210303	Цэвэр, бохир ус	5,961,025.41	4,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,829,478.00	45,249,503.00
210401	Бичиг хэрэг	2,961,858.00	4,782,000.00
210402	Тээвэр, шатахуун	22,830,970.00	28,206,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,530,000.00	2,651,350.00
210404	Ном, хэвлэл	205,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,738,000.00	4,741,210.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,563,650.00	4,868,443.00
2105	Нормативт зардал	67,307,499.20	75,404,516.72
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	59,449,839.20	63,551,207.72
210502	Хоол, хүнс	7,184,660.00	9,633,309.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	673,000.00	2,220,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,213,150.00	22,221,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,153,700.00	644,400.00
210602	Тавилга	-	1,380,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,794,500.00	3,445,400.00
210604	Урсгал засвар	8,264,950.00	16,752,100.00
2107	Томилолт, зочны зардал	3,192,000.00	4,607,000.00
210702	Дотоод албан томилолт	3,192,000.00	4,607,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,608,921.00	15,009,620.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,511,471.00	11,471,280.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	299,250.00	2,865,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	181,200.00	185,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	29,040.00
210807	Газрын төлбөр	8,000.00	8,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,455,894.00	7,086,471.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,455,894.00	7,086,471.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(6,644,533.57)	(27,659,147.79)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,681,000.00	13,046,400.00

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,681,000.00	13,046,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,681,000.00	13,046,400.00
222001	Тоног төхөөрөмж	3,759,000.00	6,154,500.00
223001	Бусад хөрөнгө	6,922,000.00	6,891,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(10,681,000.00)	(13,046,400.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(17,325,533.57)	(40,705,547.79)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		45,654,147.27
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	45,654,147.27	4,948,599.48

Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	236,581,519.55	78,364,852.74	184,720,922.39	499,667,294.68
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(9,079,920.00)	(9,079,920.00)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	236,581,519.55	78,364,852.74	175,641,002.39	490,587,374.68
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(17,677,548.50)	(17,677,548.50)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	236,581,519.55	78,364,852.74	157,963,453.89	472,909,826.18
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	236,581,519.55	78,364,852.74	157,963,453.89	472,909,826.18
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	236,581,519.55	78,364,852.74	157,963,453.89	472,909,826.18
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	813,573,263.20	813,573,263.20
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	236,581,519.55	78,364,852.74	971,536,717.09	1,286,483,089.38

Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	931,021,300.00	796,358,327.05	134,662,972.95	85.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	931,021,300.00	769,947,527.05	161,073,772.95	82.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	931,021,300.00	769,947,527.05	161,073,772.95	82.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	585,310,200.00	516,213,530.50	69,096,669.50	88.2
210101	Үндсэн цалин	271,100,000.00	260,496,474.46	10,603,525.54	96.1
210102	Нэмэгдэл	229,800,000.00	194,135,625.13	35,664,374.87	84.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,700,000.00	31,384,177.84	(5,684,177.84)	122.1
210104	Урамшуулал	58,710,200.00	30,197,253.07	28,512,946.93	51.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,560,600.00	62,677,098.00	15,883,502.00	79.8
210201	Тэтгэврийн даатгал	54,394,300.00	41,521,831.29	12,872,468.71	76.3
210202	Тэтгэмжийн даатгал	6,041,600.00	4,828,699.35	1,212,900.65	79.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,020,800.00	2,414,699.42	606,100.58	79.9
210204	Ажилгүйдлийн даатгал	3,020,800.00	4,252,868.58	(1,232,068.58)	140.8
210205	Эрүүл мэндийн даатгал	12,083,100.00	9,658,999.36	2,424,100.64	79.9

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,619,900.00	34,842,287.83	777,612.17	97.8
210301	Гэрэл, цахилгаан	6,000,000.00	4,930,659.83	1,069,340.17	82.2
210302	Түлш, халаалт	25,419,900.00	25,711,628.00	(291,728.00)	101.1
210303	Цэвэр, бохир ус	4,200,000.00	4,200,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	65,888,500.00	45,249,503.00	20,638,997.00	68.7
210401	Бичиг хэрэг	7,234,100.00	4,782,000.00	2,452,100.00	66.1
210402	Тээвэр, шатахуун	38,912,400.00	28,206,500.00	10,705,900.00	72.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,102,000.00	2,651,350.00	450,650.00	85.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,140,000.00	4,741,210.00	3,398,790.00	58.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,500,000.00	4,868,443.00	3,631,557.00	57.3
2105	Нормативт зардал	83,692,300.00	75,404,516.72	8,287,783.28	90.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	68,162,300.00	63,551,207.72	4,611,092.28	93.2
210502	Хоол, хүнс	10,830,000.00	9,633,309.00	1,196,691.00	89.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,700,000.00	2,220,000.00	2,480,000.00	47.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,500,000.00	12,341,500.00	27,158,500.00	31.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00	(4,875,100.00)	13,875,100.00	-54.2
210602	Тавилга	4,800,000.00	(2,495,900.00)	7,295,900.00	-52.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,000,000.00	3,445,400.00	554,600.00	86.1
210604	Урсгал засвар	21,700,000.00	16,267,100.00	5,432,900.00	75.0
2107	Томилолт, зочны зардал	9,000,000.00	4,607,000.00	4,393,000.00	51.2
210702	Дотоод албан томилолт	9,000,000.00	4,607,000.00	4,393,000.00	51.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,899,800.00	15,009,620.00	3,890,180.00	79.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,720,000.00	11,471,280.00	2,248,720.00	83.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,464,000.00	450,000.00	1,014,000.00	30.7
210803	Даатгалын үйлчилгээ	2,900,000.00	2,865,500.00	34,500.00	98.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	185,800.00	14,200.00	92.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.00	-	70,000.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	495,800.00	29,040.00	466,760.00	5.9
210807	Газрын төлбөр	50,000.00	8,000.00	42,000.00	16.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,550,000.00	3,602,471.00	10,947,529.00	24.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,550,000.00	3,602,471.00	10,947,529.00	24.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	26,410,800.00	(26,410,800.00)	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	26,410,800.00	(26,410,800.00)	-
222001	Тоног төхөөрөмж	-	11,674,000.00	(11,674,000.00)	-
223001	Бусад хөрөнгө	-	14,736,800.00	(14,736,800.00)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	931,021,300.00	755,652,779.26	175,368,520.74	81.2
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,619,900.00	41,208,737.83	1,411,162.17	96.7
132001	Орон нутгийн төсвөөс	42,619,900.00	41,208,737.83	1,411,162.17	96.7
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	842,747,300.00	714,444,041.43	128,303,258.57	84.8
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	842,747,300.00	714,444,041.43	128,303,258.57	84.8
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	45,654,100.00	-	45,654,100.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	45,654,100.00	-	45,654,100.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		45,654,147.27	(45,654,147.27)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,948,599.48	(4,948,599.48)	-

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3 алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 2 алдааг залруулж, 1 албан шаардлага өгсөн.

5.1 Залруулсан алдаа

1. Үндсэн хөрөнгийн тайлант хугацаанд ашиглалтад орсон 7.8 сая төгрөгийн 8 нэр төрлийн хөрөнгийн 1.1 сая төгрөгийн элэгдлийг бодуулаагүй, мөн тайлант хугацаанд шилжүүлсэн тээврийн хэрэгслийн элэгдлийг давхар бодуулж үлдэх өртгийг /-/ дүнгээр илэрхийлж тайлант хугацааны үндсэн хөрөнгийн үлдэх өртгийг 4.3 сая төгрөгөөр бууруулсан байсныг залруулсан.

2. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг 424.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийг 244.4 сая төгрөгөөр нийт 669.3 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасныг залруулав.

5.2 Албан шаардлага

Зориулалт бус зарцуулалттай холбоотой

1. Тус байгууллага нь тайлант хугацаанд 3.9 сая төгрөгийн цэвэрлэгээний материал болон хогийн уут, 0.04 сая төгрөгийн галын хорны суурь зэргийг хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардлаас, 0.01 сая төгрөгийн интернетийн зардлыг эмийн зардлаас, Нэгдсэн эмнэлгийн үзлэгийн төлбөр 0.3 сая төгрөгийг хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардлаас, аудитын төлбөр 0.9 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас, даатгалын төлбөр 0.08 сая төгрөгийг тээврийн хэрэгслийн татварын зардлаас, программын төлбөр 0.5 сая төгрөгийг эмийн зардлаас, нийт 5.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг алдаатай тооцоолсон	1	5,380.7	-	-	1	5,380.7	1	5,380.7		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан зөрүүтэй	1	669,321.9	1	669,321.9	-	-	1	669,321.9		
Дүн	2	674,702.6	1	669,321.9	1	5,380.7	2	674,702.6		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зардлыг зориулалт бусаар зарцуулсан	1	5,633.0			1	4,959.5	-	-				
Дүн	1	5,633.0			1	4,959.5	-	-				